



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/164

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22, 33 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 347 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны "Журам батлах тухай" 08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны ажиллах журмыг нэгдүгээр, Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлага, багуудын эрх, үүргийг хоёрдугаар, Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг журам, төлөвлөгөөний дагуу удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар тушаалын нэгдүгээр, хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /М.Баттүвшин/-д даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141210829

03 Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
... дугаар сарын ... өдрийн ... дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

**Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед ажиллах  
Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны  
ажиллах журам**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, хянах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг шуурхай удирдах зохион байгуулах, хэрэгжүүлэхэд Тохиолдлын удирдлагын тогтолцооны гүйцэтгэх нийтлэг чиг үүргийг тодорхойлох, түншлэл хамтын ажиллагаа, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга нь Эрүүл мэндийн сайд байх бөгөөд түүний эзгүйд Эрүүл мэндийн дэд сайд орлоно.
- 1.3 Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга Эрүүл мэндийн сайдын шууд удирдлага дор ажиллана.
- 1.4 Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь орон нутаг, мэргэжлийн байгууллага дахь эрүүл мэндийн алба-тохиолдлын удирдлагын тогтолцоо /цаашид мэргэжлийн анги гэх/-г мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангана.
- 1.5 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрсдлийн үнэлгээ хийх, арга хэмжээг төлөвлөх, нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, эрсдлийн харилцаа холбоог зохицуулах, сургалт, дадлага зохион байгуулах, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, бусад улсын албатай харилцан ажиллах, мэдээлэл солилцох зэрэг үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.
- 1.6 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь гамшгаас хамгаалах асуудал хариуцан ажиллах орон тооны албан хаагчтай байна.
- 1.7 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай болон бусад холбогдох байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.8 Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэхүү үйл ажиллагаанд нийтлэг үүрэгтэй оролцоно.
- 1.9 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь хандивлагч болон хүмүүнлэгийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр хүмүүнлэгийн тусламжийн мэргэжлийн ангиудтай хамтарч ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллана.
- 1.10 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь дараахь зарчимд суурилна. Үүнд:
- 1.10.1 Шаталсан удирдлагын тогтолцоотой байх (бүрэлдэхүүний тайван цагийн албан тушаалын зэрэглэл, шатлал идэвхжлийн үед үйлчлэхгүй) ;

- 1.10.2 Бүх төрлийн эрсдлийн хариу арга хэмжээнд тохирсон нэгдсэн бүтэц, загвартай байх;
- 1.10.3 Нөхцөл байдлын өөрчлөлтөд мэдрэг уян хатан байх

### **Хоёр. Төхиолдлын удирдлагын тогтолцооны чиг үүрэг**

- 2.1 Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Олон улсын эрүүл мэндийн дүрмийг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 2.2 Салбарын бодлого, хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, хянах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн засах арга хэмжээг авах үйл ажиллагааны төлөвлөгөө /цаашид "гамшгаас хамгаалах төлөвлөгөө" гэх / боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн /Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны дарга/-ээр батлуулах;
- 2.3 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийг бууруулах, нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах, шуурхай мэдээлэл солилцох арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.4 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах, зарцуулах, үр дүнг тооцох;
- 2.5 Үүссэн болон үүсч болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, мэргэжлийн заавар, зөвлөмж, мэдээллээр онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, Улсын онцгой комисс, Засгийн газрыг цаг тухайд нь шуурхай хангах, холбогдох шийдвэр гаргуулах;
- 2.6 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас сэргийлэх, хамгаалах чиглэлээр эрхэлсэн салбарын хэмжээнд албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, холбогдох албан тушаалтны илтгэл, мэдээлэл сонсох;
- 2.7 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлэх, ажлын тусгай горимд шилжүүлэх, гамшгийн голомтод мэргэжлийн хүмүүсийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт шуурхай томилох;
- 2.8 Салбарын хэмжээнд гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулыг зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлэх, дохиогоор ажиллах дадлага сургуулийг хийх, зарлан мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
- 2.10 Тайван цагийн горимд шуурхай удирдлагын баг ажиллах чиг үүргийг энэхүү журмаар зохицуулах;
- 2.11 Хууль тогтоомжийн хүрээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, улсын албадад томилгоот хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

2.12 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, тайланг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн албанаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх.

2.13 Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь үүссэн нөхцөл байдал, эрсдлийн төрөл, түвшнээс хамааран дараах бүтэцтэй байна.

- 2.13.1 Тандалтын баг
- 2.13.2 Төлөвлөлт, хяналтын баг
- 2.13.3 Хариу арга хэмжээний баг
- 2.13.4 Эрсдэлийн харилцаа холбооны баг
- 2.13.5 Хүний нөөц, сургалтын баг
- 2.13.6 Нөөцийн хангалтын баг
- 2.13.7 Санхүү, хөрөнгө оруулалтын баг

2.14 Шуурхай мэдээлэл солилцоход дараах байгууллагуудтай хамтран ажиллана.

2.14.1 Дараах эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллана.

Үүнд:

- 2.14.1.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв
- 2.14.1.2 Зоонозын өвчин судлалын үндэсний төв
- 2.14.1.3 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
- 2.14.1.4 Гэмтэл согог судлалын үндэсний төв
- 2.14.1.5 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- 2.14.1.6 Эрүүл мэндийн хөгжлийн төв
- 2.14.1.7 Бүх шатны эрүүл мэндийн байгууллага

2.14.2 Бусад салбар хоорондын байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллана.Үүнд:

- 2.14.2.1 Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
- 2.14.2.2 Онцгой байдлын ерөнхий газар
- 2.14.2.3 Цагдаагийн ерөнхий газар
- 2.14.2.4 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- 2.14.2.5 Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв
- 2.14.2.6 Бусад

Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
03 дугаар сарын 29 өдрийн  
8/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны  
удирдлага, багуудын эрх, үүрэг**

**Нэг. Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны  
удирдлагын эрх, үүрэг**

1.1 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын баг нь Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга, менежер, тандалтын баг, төлөвлөлт, хяналтын баг, хариу арга хэмжээний баг, эрсдэлийн харилцаа холбооны баг, хүний нөөц, сургалт баг, нөөцийн хангалтын баг, санхүү, хөрөнгө оруулалтын багийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй байна.

1.2 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргын эрх, үүрэг:

1.2.1 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоог ерөнхий удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг баталгаажуулан, холбогдох шийдвэрийг гарган хяналт тавих;

1.2.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед холбогдох үүрэг даалгаврыг менежерт, шаардлагатай үед багийн ахлагч нарт өгөх;

1.2.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын эрсдэл, хохирол, хэрэгцээний үнэлгээг хийлгэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед салбарын тогтвортой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

1.2.4 Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар болон бусад улсын албатай хамтран ажиллах;

1.2.5 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын нөөцийг нэгдсэн удирдлагаар хангах;

1.2.6 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шийдвэр гаргах.

1.3 Эрүүл мэндийн улсын алба- Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерийн эрх, үүрэг:

1.3.1 Менежер Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны гамшгаас хамгаалах төлөвлөгөө болон удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу багуудын өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоог ханган, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

1.3.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед тулгамдсан асуудлыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажилагааны тэргүүлэх чиглэлийг тогтоож, хариу арга хэмжээг төлөвлөх, санал, шийдвэрийн төслийг боловсруулах, холбогдох

мэдээ мэдээллээр Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргыг хангах;

1.3.3 Шинээр дайчлагдсан ажилтнуудад хийх ажлын чиглэл, удирдамжийг танилцуулах;

1.3.4 Удирдлагын баг, бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

1.3.5 Эрсдэлийн үеийн бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянан баталгаажуулах;

1.3.6 Удирдлагын багийн хурлыг 7 хоногт 2 удаа зохион байгуулж, үйл ажиллагааны гүйцэтгэлтэй танилцан тулгамдсан асуудлыг шийдвэрлэх;

1.3.7 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын баг ажиллахад шаардагдах байр, холбоо, зарлан мэдээллийн хэрэгсэл, хувцас, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;

1.3.8 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерийн нарийн бичгийн ажилтнаар Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн яаралтай тусламж, гамшгийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн ажиллана.

#### 1.4 Тандалтын багийн эрх, үүрэг

1.4.1 Тандалтын багийн ахлагч нь Эрүүл мэндийн сайдын Халдварт өвчний асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх, нарийн бичиг нь Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Нийтийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтсийн дарга байна.

1.4.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлыг үүсгэгч үйл явдлын төрлөөс хамаарч эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийх, эрсдэлийн үнэлгээний тайланг менежерт хүргүүлэх;

1.4.3 Үйл явдлын тархалт, өрнөл, эрсдэлийг тогтоох, дэгдэлтийн судалгаа тандалт, дүн шинжилгээ хийж, хэтийн төлөвийг тодорхойлж менежерт танилцуулах;

1.4.4 Улс, орон нутаг, байгууллагын хэмжээнд ажиллах тандалтын багийн бэлэн байдлыг хангаж, уялдаа холбоог мэргэжил арга зүйгээр хангах, тандалт судалгаа хийх итгэмжлэгдсэн лаборатори, бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

1.4.5 Хавьтал, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, хянах, халдварын голомтыг халдваргүйжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;

1.4.6 Тандалт, тархвар зүйн чиглэлээр шаардлагатай заавар, журам, зөвлөмж, албан даалгавар, түр заавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулах батлуулах;

1.4.7 Аюулт үзэгдэл, осол, халдварт өвчний дэгдэлт, цар тахал зэргийн эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг нотолгоонд тулгуурлан боловсруулах, баталгаажуулах, холбогдох мэргэжилтнүүдийг сурган дадлагажуулах.

## 1.5. Төлөвлөлт, хяналтын багийн эрх, үүрэг

1.5.1 Төлөвлөлт, хяналтын багийн ахлагч нь Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, нарийн бичиг нь Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн дарга байна.

1.5.2 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ, дадлага сургуулилтын дүгнэлтэд тулгуурлан бусад багуудаас шуурхай хүлээн авч, нэгтгэн Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах, тодотгол хийх;

1.5.3 Салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгах;

1.5.4 Судалгаанд үндэслэн төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг бусад багуудаас болон эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авах;

1.5.5 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэн үйл ажиллагааны бэлэн байдлын төлөвлөгөөг 7 хоногоор боловсруулан, баталгаажуулах;

1.5.6 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний биелэлтэд хяналт үнэлгээ хийж Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэх;

1.5.7 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэсэн үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөний биелэлтийг гарган, хэрэгжилтийг хянан;

1.5.8 Төлөвлөлт, тандалт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ мониторинг хийх;

1.5.9 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тайланг сар бүр багуудаас хүлээн авч, нэгтгэн, менежерт танилцуулах.

## 1.6 Хариу арга хэмжээний багийн эрх, үүрэг

1.6.1 Хариу арга хэмжээний багийн ахлагч нь Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, нарийн бичиг нь Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн байна.

1.6.2 Хариу арга хэмжээний багийн төлөвлөлтийг хийж, өдөр тутмын хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;

1.6.3 Голомтод хариу арга хэмжээ зохион байгуулах, эрсдэлийг бууруулах, голомтын халдваргүйжүүлэлтийг зохион байгуулах цомхотгох арга хэмжээг авах;

1.6.4 Мэргэжлийн төв байгуулагуудаас томилогдон ажиллаж байгаа шуурхай арга хэмжээний баг, мэргэжлийн ангийг ажиллуулах, хувилбаруудыг тооцох, сонгон

хэрэгжүүлэх, шаардлагатай заавар, зөвлөмж, албан даалгавар боловсруулан, батлуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах;

1.6.5 Дайчлагдан ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний өртөлтийн өмнөх болон дараах урьдчилан сэргийлэлтэд хамруулах, эрүүл мэндийг хянах ажлыг зохион байгуулах;

1.6.6 Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын өдөр тутмын бэлэн байдлыг хангуулах, мэдээллээр хангах.

1.6.7 Хариу арга хэмжээний чиглэл, цар хүрээ, шаардагдах нөөцийг батлагдсан аргачлалд тулгуурлан тооцоолох холбогдох багуудыг тооцоолол бүхий мэдээллээр хангах;

1.6.8 Хариу арга хэмжээний явц, үр дүнг хянан мэргэжил арга зүйгээр хангах;

1.6.9 Хариу арга хэмжээний тайланг нэгтгэн, танилцуулах.

1.6.10 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээ авах эрүүл мэндийн улсын алба-тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын бүрэлдэхүүнд холбоо, зарлан мэдээллийг цаг хугацаанд зохион байгуулах.

1.7 Эрсдэлийн харилцаа холбооны багийн эрх, үүрэг

1.7.1 Эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч нь Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулалтын газрын дарга, нарийн бичиг нь Эрсдэлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн байна.

1.7.2 Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан тандалтын баг, холбогдох мэргэжлийн багаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн нэгдсэн үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг бэлтгэн удирдлагын багт өдөр тутам танилцуулах;

1.7.3 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоог дотоод мэдээ мэдээлэл, харилцаа холбоогоор хангах

1.7.4 Өдөр тутмын хянагдсан мэдээ, мэдээлэл, сайн туршлага, эрсдэлийг даван туулсан түүх зэргийг олон нийтэд мэдээлэх;

1.7.5 Хүн амын дундах хандлага, ойлголтын судалгааг хийж, залруулга мэдээлэл бэлтгэн гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээнд дүн шинжилгээ мониторинг хийж, цаашдын чиглэлийг боловсруулах;

1.7.6 Эрүүл мэндийн яамны цахим хуудас, фейсбүүк хуудсаар дамжуулан хүн амыг мэдээллээр тогтмол хангах, зорилтот бүлгийн мэдээллийг хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай мэдээллийг бэлтгэн түгээх, нээлттэй утас ажиллуулах;

1.7.7 Хэвлэлийн бага хурал зохион байгуулах;

1.7.8 Олон улсын байгууллагад үйл явдлын талаарх болон хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээг тогтмол хүргэх.

1.8 Хүний нөөц, сургалтын багийн эрх, үүрэг



1.8.1 Хүний нөөц, сургалтын багийн ахлагч нь Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга дарга, нарийн бичиг нь Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч байна.

1.8.2 Тохиолдлын удирдлагын тогтолцооны үйл ажиллагаа болон хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хүний нөөцийн судалгааг гарган дайчлан ажиллуулах, хуваарилах;

1.8.3 Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг мөрдөн ажиллах заавар журмаар хангах, түргэвчилсэн сургалт зохион байгуулах;

1.8.4 Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг холбогдох байгуулагуудтай хамтран журамд заасны дагуу зохион байгуулах;

1.8.5 Дайчлагдан ажилласан резидент эмч, оюутны сургалтын хөтөлбөрийг дүйцүүлэн тооцох заавар, зөвлөмж боловсруулж баталгаажуулах;

1.8.6 Дадлага сургуулилт, түргэвчилсэн сургалтад шаардагдах гарын авлага, материалыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран боловсруулж, түгээх;

#### 1.9 Нөөцийн хангалтын багийн эрх, үүрэг

1.9.1 Нөөцийн хангалтын багийн ахлагч нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд дарга, нарийн бичиг нь Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч байна.

1.9.2 Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж, оношлуурын нөөцийг тооцож, бүрдүүлж, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

1.9.3 Нөөцийг хадгалах, хамгаалахад шаардлагатай агуулах, байр байгууламжийн бэлэн байдлыг хангах, зохицуулах;

1.9.4 Орон нутаг, эрүүл мэндийн байгууллагад нөөцийг түгээх, аюулгүй байдлыг хангах;

1.9.5 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоонд шаардлагатай хувцас, багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх хамгаалах ажлыг зохион байгуулах;

1.9.6 Аврах ажилд оролцох, улсын албаны мэргэжлийн ангиудыг шилжүүлэн ажиллуулах, нөхцөл байдлын өөрчлөлт орсон үед байр хүнсний болон бусад материалаар найдвартай хангах нөхцлийг судлан хангалтыг хийх;

1.9.7 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дадлага сургуулилт хийх, танхим талбай зурвас байгуулах, ашиглалтад хяналт тавих.

#### 1.10 Санхүү, хөрөнгө оруулалтын багийн эрх, үүрэг

1.10.1 Санхүү, хөрөнгө оруулалтын багийн ахлагч нь Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга,

нарийн бичиг нь Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Салбарын хөрөнгө оруулалт, эдийн засаг, санхүүжилт, зээл тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

1.10.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах хойшлуулашгүй арга хэмжээнд татан оролцуулах, хүний нөөц, техник, материал, хэрэгсэл зэрэг шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, нөөцийн мэдээллийг цахимжуулах, хяналт тавихад шаардагдах санхүүжилт, хөрөнгө оруулалтын тооцоог хийж, шийдвэрлүүлэн ажиллах;

1.10.3 Багуудын болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан цагийн тооцоог бүртгэх, цалин, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцож олгох;

1.10.4 Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгох, гэрээ хэлцэл хийх;

1.10.5 Шаардлагатай худалдан авалтыг хууль дүрмийн дагуу шуурхай зохион байгуулах;

1.10.6 Өдөр тутмын санхүүгийн тайланг менежерт танилцуулах, архив үүсгэн баримтжуулах;

1.10.7 Эрүүл мэндийн улсын алба-тохиолдол удирдлагын тогтолцооны нөөц бүрдүүлэхэд шаардлагатай эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгийн даатгал, санхүүгийн болон эрсдэлийн сантай холбоотой эрх зүйн зохицуулалт бий болгох

1.11 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын нарийн бичиг нь багийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд оруулах саналыг нэгтгэн, тайван цагийн горимд жилд нэг удаа эсхүл шаардлагатай үед удирдлагын багт, идэвжлийн үед тухай бүр Төлөвлөлт, хяналтын багт хүргүүлэх, тайланг мөн хугацаанд хүргүүлэх;

1.12 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын нарийн бичиг нь багийн төлөвлөгөө, тайлан, нөхцөл байдлын 7 хоногийн тайлан, шаардлагатай тохиолдолд өдөр тутам цагийн байдлын мэдээг менежерийн нарийн бичгийн ажилтанд тухай бүрт, тандалтын багт үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног бүрийн баасан гарагийн 10 цагт хүргүүлэх;

1.13 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын нарийн бичиг нь ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд тус багийн ахлагч багийн гишүүдээс томилон ажиллуулна.

1.14 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын тухай мэдээ мэдээллийг цуглуулах, нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

1.15 Бусад улсын алба болон Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөөнд тайван цагийн горимд ажиллах жилд нэгээс доошгүй удаа, гамшиг,

нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын идэвхжлийн үед тухай бүр тодотгол хийх харилцан хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах;

1.16 Орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад материалыг Онцгой байдлын ерөнхий газарт жил бүрийн 6 дугаар сарын 30, дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэх;

### **Хоёр. Эрүүл мэндийн улсын алба-тохиолдол удирдлагын тогтолцооны удирдлага, орлох албан тушаалтан**

2.1 Энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдол удирдлагын тогтолцооны багийн бүрэлдэхүүн, удирдлагуудын орлон ажиллах албан тушаалтнууд ажил үүргийн хуваарийн дагуу ажиллана. Шаардлагатай тохиолдолд яамны дэргэдэх холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, ажилтанг нэмэлтээр татан оролцуулж болно.

2.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төрөл, эрсдэлийн түвшингээс хамаарч Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо, түүний удирдлагын бүрэлдэхүүн (удирдлагын баг) хэсэгчлэн буюу бүхэлдээ идэвхжиж болно.

2.3 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо түүний удирдлагын багт өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдэгдэнэ.

2.4 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын ахлагч нар менежерийн удирдлагын дор бэлэн байдлын түвшинтэй уялдуулан тогтмол хуралдаж тулгамдсан асуудлыг хэлэлцэн, шаардлагатай шийдвэрийг саналыг боловсруулж Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргад мэдээлж, шийдвэр гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллана.

2.5 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн ахлагч багийн чиг үүргийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, мэдээллийг менежерт хүргэн шаардлагатай гэж үзвэл тулгамдсан асуудлаар Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлага хуралдах саналыг гаргана.

### **Гурав. Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга, менежер, багийн ахлагч түүнийг орлох албан тушаалтан**

Шифр	Гамшгаас хамгаалах албан үүрэг	Албан тушаал	Орлох албан тушаалтан
01	Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн дэд сайд

	удирдлагын тогтолцооны дарга		
02	Менежер	Төрийн нарийн бичгийн дарга	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
03	Тандалтын багийн ахлагч	Эрүүл мэндийн сайдын Халдварт өвчний асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын албаны дарга
04	Төлөвлөлт, хяналтын багийн ахлагч	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга
05	Хариу арга хэмжээний багийн ахлагч	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга
06	Эрсдлийн харилцаа холбооны багийн ахлагч	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Халдварт бус өвчний хяналт сэргийлэлтийн хэлтсийн дарга
07	Хүний нөөц, сургалтын багийн ахлагч	Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга	Төрийн захиргааны удирдлагын газрын Захиргаа, хуулийн хэлтсийн дарга
08	Нөөцийн хангалтын багийн ахлагч	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дэд дарга	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга
09	Санхүү, хөрөнгө оруулалтын багийн ахлагч	Эрүүл мэндийн эдийн засгийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Эрүүл мэндийн эдийн засгийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
10	Менежерийн нарийн бичгийн ажилтан	Эмнэлгийн тусламжийн зохицуулах газрын	бодлого, хэрэгжилтийг Эмнэлгийн яаралтай

		тусламж, гамшгийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн	
11	Мэргэжлийн анги	Тухайн мэргэжлийн ангийн дарга (байгууллагын дарга, захирал)	Тухайн мэргэжлийн ангийн дарга (байгууллагын орлогч дарга, захирал)

3.1 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын ахлагч, мэргэжлийн ангийн дарга нар менежерийн удирдлагын дор бэлэн байдлын түвшинтэй уялдуулан тогтмол хуралдаж тулгамдсан асуудлыг хэлэлцэн, шаардлагатай шийдвэрийн саналыг боловсруулж Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны даргад мэдээлж, шийдвэр гаргуулан хэрэгжилтийг ханган ажиллана.

3.2 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны мэргэжлийн анги, орон нутгийн эрүүл мэндийн алба-тохиолдлын удирдлагын тогтолцооны дарга буюу байгууллагын дарга /захирал нар нь тухайн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төрөл, хамрах хүрээнээс хамаарч тухай бүрт багийн гишүүнээр ажиллана.

**Дөрөв. Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны дотоод үйл ажиллагааны зохицуулалт**

4.1 Эрүүл мэндийн улсын алба-тохиолдол удирдлагын тогтолцооны дотоод үйл ажиллагааны зохицуулалт нь тайван цагийн ба идэвхжлийн үеийн гэсэн үндсэн хоёр горимтой байна.

4.2 Тайван цагийн үед ажиллах Шуурхай удирдлагын баг дараахь бүрэлдэхүүнтэй байна.

Д/д	Багийн бүрэлдэхүүн	Албан тушаал
1.	Менежер	Нийтийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтсийн дарга
2.	Зохицуулагч	Эрсдлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
3.	Орон тооны гишүүн	Дархлаажуулалт болон дархлаажуулалт бүхий халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
4.	Орон тооны гишүүн	Нийтийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтсийн ахлах шинжээч

5.	Орон тооны бус гишүүн	Эмнэлгийн яаралтай тусламж, гамшгийн үеийн бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн
6.	Орон тооны бус гишүүн	Сэтгэц, зан үйлийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
7.	Орон тооны бус гишүүн	Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч
8.	Орон тооны бус гишүүн	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
9.	Орон тооны бус гишүүн	Химийн аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
10.	Орон тооны бус гишүүн	Осол гэмтэл, хүчирхийллийн асуудал хариуцсан мэргэжилтэн
11.	Орон тооны бус гишүүн	Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн хэлтсийн шинжээч
12.	Орон тооны бус гишүүн	Статистик мэдээллийн боловсруулалт, зохицуулалт хариуцсан шинжээч
13.	Орон тооны бус гишүүн	Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн өгөгдлийн сангийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
14.	Орон тооны бус гишүүн	Яамны харьяа байгууллагын төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн

4.3 Тайван цагийн горимын үед дайчлан ажиллуулах албан хаагчдын бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга батална.

4.4 Тайван цагийн горимоор ажиллахдаа Шуурхай удирдлагын баг дараахь үүргийг гүйцэтгэнэ.

4.4.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн төлөвлөгөөг төрөл, эрсдлийн түвшинтэй уялдуулан боловсруулж, батлуулах;

4.4.2 Үйл явдал болон шалгуур үзүүлэлтэд суурилсан тандалтын мэдээг цуглуулж, нэгтгэн, хариу арга хэмжээний чиглэл, зөвлөмж гарган хэрэгжүүлэх;

4.4.3 Нийгмийн эрүүл мэндийн онцгой үйл явдал, осол, аюулт үзэгдлийн бэлэн байдлыг хангахтай холбоотой онолын болон дадлагажуулах сургалт зохион байгуулах;

4.4.4 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын хариу арга хэмжээний эргэмж, үнэлгээ хийх, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх;

4.4.5 Хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны материал бэлтгэн сурталчлах;

4.4.6 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.4.7 Тандалт, шуурхай удирдлагын нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэлээр мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр хадгалах.

4.5 Өөрийн чиг үүргийн хүрээнд бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг удирдан зохион байгуулах Шуурхай удирдлагын нэгж Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, зарим аймгуудын Эрүүл мэндийн газарт ажиллана.

4.6 Энэхүү журмын 4.5 дахь заалтад зааснаас бусад тусгай мэргэшлийн төв, төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт шуурхай удирдлагын нэгжтэй байж болно.

4.7 Шуурхай удирдлагын баг нь Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай шуурхай мэдээлэл солилцон хамтран ажиллана.

4.8 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны багууд ажлын өдрүүдэд 1 цаг, ажлын бус өдрүүдэд 2 цагийн дотор цугларна.

4.9 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо нь 7/24 цагаар, шаардлагатай үед уртасгасан цагаар ажиллана.

4.10 Тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудад ажиллах ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй (эзгүй, эрсдэлд өртсөн гм) тохиолдолд орлон ажиллах ажилтныг дайчлан ажиллуулна .

4.11 Энэ журмын 4.10 дахь заалтад заасан ажилтнуудтай холбоо тогтоох боломжгүй тохиолдолд Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежерийн шийдвэрээр тухайн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, олон жил ажилласан мэргэжилтнийг сонгон ажиллуулна.

4.12 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төрөл,эрсдэлийн түвшин, нөхцөл байдлаас хамаарч Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны менежер, Эрсдэлийн харилцаа холбооны баг, Санхүү, хөрөнгө оруулалтын баг, Нөөцийн хангалтын багийн гишүүд байнгын бүрэлдэхүүнтэй байна. Харин Тандалтын баг, Төлөвлөлт, хяналтын баг, Хариу арга хэмжээний баг, Хүний нөөц, сургалтын багийн бүрэлдэхүүн, тусгай мэргэшлийн төв, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн удирдлагыг ялгаатай томилно.

4.13 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлагыг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотор байршсан, хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, дэд бүтэц, аюулгүй байдлыг хангасан байртай байна

4.14 Уг байр нь хурлын танхим, албан тасалгаа, дотоод сүлжээний өрөө, гал тогооны хэсэгтэй байна. Байрыг тайван цагт сургалт хурал зохион байгуулахад ашиглана.

4.15 Хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл, байдал үүссэн тохиолдолд шилжүүлэн ажиллуулах нөөц байр болон нүүдлийн төвтэй байна.

4.16 Тайван цагт мэдээлэл солилцох цахим хуудас, тусгайлсан цахим шуудангийн хаяг, суурин утастай байна.

### **Тав. Сургалт**

5.1 Гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгаж, хөтөлбөр удирдамжийн дагуу зохион байгуулна. Үүнд:

5.1.1 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны удирдлага, багуудын хамтарсан сургалт дадлагыг 2 жил тутамд нэг удаа;

5.1.2 Мэргэжлийн ангийн дадлага сургуулилтыг жил бүр;

5.2 Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцоо, орон нутгийн алба, мэргэжлийн анги үүсч болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын төрөл, нөхцөл байдал, эрсдэл, давтамжийг харгалзан эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн мэргэжилтний сургалт, дадлагыг тухай бүр зохион байгуулна.

5.3 Улсын албад хоорондын хамтарсан сургалт, дадлагыг албадын дарга нарын шийдвэрээр зохион байгуулна.

5.4 Онцгой байдлын ерөнхий газартай хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулна.

### **Зургаа. БУСАД**

6.1 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан улс, орон нутгийн гамшгаас хамгаалах томилгоот албан хаагчийг онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын шагналаар шагнуулах асуудлыг шийдвэрлэнэ.

6.2 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын голомтод үүрэг гүйцэтгэсэн ажилтны томилолтын зардлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох, мөн сэлгээж амрах, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулж болно.

6.3 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас хамгаалах үүрэг гүйцэтгэх үед хөдөлмөрийн чадвараа түр болон бүрмөсөн алдсан, амь насаа алдсан тохиолдолд албан хаагч болон түүний гэр бүлд тэтгэмж, нөхөн олговор олгох асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

6.4 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын аюулаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, техник, хэрэгсэл, хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, бусад албан дотоод асуудалд оролцохыг хориглоно.



Эрүүл мэндийн сайдын 2021 оны  
03 дугаар сарын 29 өдрийн  
1/164 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**Эрүүл мэндийн улсын алба-Тохиолдлын удирдлагын тогтолцооны  
багуудын бүрэлдэхүүн**

**1.Тандалтын баг**

Багийн ахлагч:

А.Амбасэлмаа, Эрүүл мэндийн сайдын  
Халдварт өвчний асуудал хариуцсан орон  
тооны бус зөвлөх

Багийн ахлагчийг орлох  
албан тушаалтан:

Ж.Байгалмаа, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн Тандалтын албаны дарга

Нарийн бичиг:

Г.Болдмаа, Нийтийн эрүүл мэндийн  
тусламжийн бодлого, хэрэгжилтийг  
зохицуулах газрын Нийтийн эрүүл мэндийн  
хариу арга хэмжээ, халдварт өвчний хяналт,  
сэргийлэлтийн хэлтсийн дарга

Гишүүд

Л.Пүрэвдулам, Нийтийн эрүүл мэндийн  
тусламжийн бодлого, хэрэгжилтийг  
зохицуулах газрын Хоол тэжээл, хүнсний  
аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Э.Тэмүүлэн, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн Дэд захирал

О.Дашпагам, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны  
дарга

С.Энхзаяа, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн Нэгдсэн лабораторийн  
албаны дарга

Д.Наранзул, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн тархвар судлаач

А.Билэгт, Халдварт өвчин судлалын  
үндэсний төвийн тархвар судлаач

Б.Сувд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн албаны дарга

Б.Амгаланбаяр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дэд захирал

Б.Уянга, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлаач

Л.Зэндмаа, Нийслэлийн эрүүл мэндийн газрын орлогч дарга

О.Энхзаяа, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Н.Мөнхжаргал, Монголын талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийн 3 дугаар төгсөгч

Б.Чинчулуун, Монголын талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийн 5 дугаар төгсөгч

Т.Доржготов, Монголын талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийн 5 дугаар төгсөгч

У.Наранцэцэг, Монголын талбарын тархвар судлалын сургалтын хөтөлбөрийн 7 дугаар төгсөгч

О.Ариунтуяа, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

## **2.Төлөвлөлт, хяналтын баг**

Багийн ахлагч:

П.Эрхэмбаяр, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Багийн ахлагчийг орлох албан тушаалтан:

Д.Ганцэцэг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга

Нарийн бичиг:

С.Жаргалсайхан, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Янжмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Т.Дашцэрэн, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга

Д.Баярсайхан, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга

А.Өнөржаргал, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч

П.Оюунцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын Засгийн газрын үйл ажиллагаа, үндсэн чиглэлийн төлөвлөлт хариуцсан шинжээч

С.Энхжин, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч

Э.Оюунсүрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

П.Ганчимэг, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологи, системийн нэвтрүүлэлт хариуцсан мэргэжилтэн

Э.Цацрал, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны дарга

Д.Дэлгэрмаа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга

Ш.Тэгшбаяр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Гамшиг, онцгой байдлын үеийн болон яаралтай түргэн тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

### 3. Хариу арга хэмжээний баг

Багийн ахлагч:

Б.Буянтогтох, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Багийн ахлагчийг орлох албан тушаалтан:

М.Оюунчимэг, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Ц.Тунгалагтамир, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Э.Золжаргал, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн хэлтсийн дарга

С.Энхцолмон, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Анхан шатны тусламжийн хэлтсийн дарга

М.Номингэрэл, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Отгончимэг, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чанар хүртээмж хариуцсан мэргэжилтэн

Н.Норовбанзад, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Анхан шатны тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан ахлах зохион байгуулагч

С.Ундармаа, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Эрүүл мэндийн даатгалын бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Х.Цогзолмаа, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Анхан шатны тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Р.Баянмөнх, Цэргийн төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

М.Тунсаг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тусламж үйлчигээ эрхэлсэн дэд захирал

Д.Отгонбаяр, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэндийн тандалт шуурхай удирдлагын албаны дарга

М.Мөнхдэлгэр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Э.Энхжаргал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Ж.Оюунцэцэг, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

М.Чимгээ, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дарга

Б.Галсанцэдэн, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дарга

З.Балдандугар, Нийслэлийн Баянгол дүүргийн Нэгдсэн эмнэлгийн дарга

#### 4. Эрсдэлийн харилцаа холбооны баг

Багийн ахлагч: Л.Энхсайхан, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Багийн ахлагчийг орлох албан тушаалтан: Б.Бямбатогтох, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Халдварт бус өвчний хяналт сэргийлэлтийн хэлтсийн дарга

Нарийн бичиг: А.Долгорханд, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Эрсдэлийн харилцаа, хариу арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Д.Нарангэрэл, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Коронавируст халдварын хяналт, сэргийлэлт, тандалт хариуцсан ахлах шинжээч

Д.Баясгалан, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн удирдлагын бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч

А.Оюунгэрэл, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Даатгуулагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Уянга, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын

Осол гэмтэл, хүчирхийллийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Б.Оролзодмаа, Нийтийн эрүүл мэндийн  
тусламжийн бодлого, хэрэгжилтийг  
зохицуулах газрын Нөхөн үржихүй, хүүхэд,  
өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Ууганбаяр, Эрүүл мэндийн сайдын хэвлэл  
мэдээллийн зөвлөх

Э.Сэлэнгэ, Эрүүл мэндийн сайдын Хэвлэл  
мэдээллийн ажилтан

Б.Билгүүн, Хэвлэл мэдээллийн зохицуулагч

Д.Нарантуяа, Нийгмийн эрүүл мэндийн  
үндэсний төвийн Ерөнхий захирал

Б.Баярмаа, Сэтгэцийн эрүүл мэндийн  
үндэсний төвийн Дэд захирал

С.Гэрэлмаа, Нийгмийн эрүүл мэндийн  
үндэсний төвийн албаны дарга

О.Даариймаа, Зоонозын халдварт өвчин  
судлалын үндэсний төвийн их эмч

Б.Баатарсүрэн, Нийслэлийн эрүүл мэндийн  
газрын Эмнэлгээс шалтгаалах халдварт  
өвчний асуудал хариуцсан ахлах  
мэргэжилтэн

Р.Мөнгөн, Нийслэлийн эрүүл мэндийн  
газрын хэвлэл мэдээллийн ажилтан

Г.Тэмүүжин, Нийгмийн эрүүл мэндийн  
үндэсний төвийн зураглаач

Б.Нарангэрэл, Гэмтэл согог судлалын  
үндэсний төвийн Хэвлэл мэдээллийн  
ажилтан

П.Балжир, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн  
Хэвлэл мэдээллийн ажилтан

А.Сарантуяа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн хэвлэл мэдээллийн ажилтан

Б.Ундрах, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрсдэлийн мэдээлэл харилцаа холбооны мэргэжилтэн, сэтгүүлч

Ц.Жаргалан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

С.Чимидцэрэн, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Лабораторийн Био-аюулгүй ажиллагаа, оношзүйн зөвлөх (зөвшилцсөнөөр)

П.Тина, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Ж.Алтантуяа, Азийн хөгжлийн банкны Нийгмийн салбарыг хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Л.Дэлгэрзул, Дэлхийн банкны Эрсдэлийн харилцаа холбоо, олон нийтийн оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

## 5. Хүний нөөц, сургалтын баг

Багийн ахлагч:

Б.Бумдэлгэр, Төрийн захиргааны удирдлагын газрын Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Багийн ахлагчийг орлох албан тушаалтан:

Л.Дашравдан, Төрийн захиргааны удирдлагын газрын Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Д.Баярмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч

Гишүүд:

С.Алтанбагана, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын



Анхан шатлалын тусламжийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

Г.Нэмэхбаяр, Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

Б.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирал

Б.Дашлхүмбэ, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга

Д.Баярхүү, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны Сувилахуй, тусгай мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн

П.Бумцэнд, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны албаны эрүүл мэндийн үндэсний тооцооны мэдээний сан хариуцсан мэргэжилтэн

А.Биндэрьяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн мэдээллийн албаны сервер, системийн админ мэргэжилтэн

Б.Одгэрэл, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Захиргаа, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Т.Баясгалан, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил дээшлүүлэх институтын захирал

Р.Отгонбаяр, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол- Японы эмнэлгийн захирал

Ч.Доржгүнсмаа, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан

Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн сургалт, хүний нөөцийн албаны дарга /менежер /арга зүйч нар

## 6. Нөөцийн хангалтын баг

Багийн ахлагч:

Н.Гэрэлт-Од, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмж, төлөвлөлтийн асуудал хариуцсан дэд дарга

Багийн ахлагчийг орлох албан тушаалтан:

Ш.Туул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга

Нарийн бичиг:

Ч.Амаржаргал, Төрийн захиргааны удирдлагын газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч

Гишүүд:

О.Оюунчимэг, Төрийн захиргааны удирдлагын газрын Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Б.Сансармаа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Оюунтуяа, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн оношилгоо, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Жаргал, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Мөнхтуул, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Э.Буяндэлгэр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын ахлах мэргэжилтэн

Ш.Ариунзаяа, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын мэдээний сан хариуцсан мэргэжилтэн

Р.Энхсүрэн, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын ахлах мэргэжилтэн

Э.Мэргэншагай, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэргэжилтэн

Н.Амарбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын мэргэжилтэн

М.Долгион, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын мэргэжилтэн

Б.Чимэддорж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын мэргэжилтэн

Б.Санж-Очир, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэргэжилтэн

З.Отгонбаяр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

## **7. Санхүү, хөрөнгө оруулалтын баг**

Багийн ахлагч:

Д.Нарантуяа, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга

Багийн ахлагчийг орлох

албан тушаалтан:

Т.Хонгорзул, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

У.Сүхдарь, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Г.Амаржаргал, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Батчимэг, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Бат-Ундрал, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Уранхайч, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн